



**ОРХОН АЙМАГ
ЖАРГАЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны 12 дугаар сарын 31

Дугаар 02/18

Жаргалант сум

┌ **Хоршоо хөгжүүлэх сангийн** ┐
тайланг дүгнэх тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн 48 дугаар зүйлийн 48.1, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/361 дүгээр тушаалын хавсралт “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 3.4.6 дэх заалт, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 31-ний ээлжит III хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Жаргалант сумын “Хоршоо хөгжүүлэх сангийн” 2024 оны жилийн эцсийн тайлангийн хэрэгжилтийг 100 хувь “Хангалттай” гэж дүгнэсүгэй.

ДАРГА



Ш.БИЛГҮҮНБААТАР

1024010076

ОРХОН АЙМГИЙН ЖАРГАЛАНТ СУМЫН “ХОРШООГ ХӨГЖҮҮЛЭХ САН”-ГИЙН
2024 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

2024.12.26.

Жаргалант

Анх 2011 оноос хойш Сум хөгжүүлэх сангаас нийт 66 иргэнд 542,9 сая төгрөгийн зээл олгогдсон байна. Үүний үр дүнд 132 ажлын байр нэмэгдэж, 38 ажлын байр хадгалагдаж үлдсэн байна.

- 2024 оны байдлаар “Хоршоог хөгжүүлэх сангийн дансанд 63,2 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, газар тариалангийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 1 хоршооны /БЛГЯ/ “30 га талбайд төмс, хүнсний ногоо тариалах” төслийг Төсөл сонгон шалгаруулах хорооны шийдвэрээр 100 сая төгрөгөөр санхүүжүүлсэн байна. Төсөл хэрэгжиж эхэлсний үр дүнд 32 ажлын байр шинээр нэмэгдсэн байна.
- Зээл олголтын чиглэлээр авч үзвэл:

№	Үндсэн чиглэл	Төслийн үйл ажиллагааны чиглэл	Хаяг	Төсөл хэрэгжүүлэгч	Төслийн санхүүжилт хүссэн дүн	Олгогдсон дүн
1	Төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ тариалах, боловсруулах	"30 га тариалангийн талбайд төмс, хүнсний ногоо тариалах"	Дулаан-Уул баг хөдөө	"БЛГЯ" хоршоо	100.000.000	100.000.000
						100.000.000

- Өнөөдрийн байдлаар 9 зээлдэгчийн 198,004,251 төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй, сангийн үлдэгдэл 82,1 сая төгрөг байна.
- Жаргалант сумын “Хоршоог хөгжүүлэх сан”-гийн чанаргүй зээлийн ангилалд 2 иргэний 2.555.410 төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна.
- Төсөлд хяналт тавих чиг үүрэг бүхий Хяналтын зөвлөл нь сангаас зээл авч, чанаргүй зээлийн ангилалд орсон зээлдэгчидтэй дараах чиглэлээр хамтран ажиллалаа. Үүнд:
 - Чанаргүй зээлийг багасгах
 - Эргэн төлөлтийг сайжруулах, барагдуулах
 - Албан мэдэгдэл хүргэх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Үүний үр дүнд чанаргүй зээлийн ангилалтай 1 хоршооны зээлийг барагдуулж, албан ёсны бүртгэлгүй, хаяг тодорхойгүй 1 зээлдэгчийн зээлийн төлөлтийг эхлүүлсэн.

Одоо үлдэгдэлтэй байгаа зээлдэгчээр авч үзвэл:

Д/д	Зээл олгосон он	Зээл олгосон дүн	Үлдэгдэлтэй байгаа зээлдэгчийн тоо	Үлдэгдэлтэй байгаа зээлдэгчийн зээлийн үлдэгдэл	Зээлийн ангилал
1	2013 он	2,000,000	1	573,800	Найдваргүй
2	2016 он	5,000,000	1	1,9871,610	Найдваргүй
3	2023 он	103,000,000	6	93,848,841	Хэвийн
4	2024 он	100,000,000	1	101,600,000	Хэвийн
	Нийт дүн		9	198,004,251	

ХЯНАСАН:

ЖАРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГА

Л.УЧРАЛ

ТАЙЛАН БИЧСЭН:

ХААТ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН

Ц.ЭНХЗАЯА